

УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ПРАГМАТИК ХАНДЛАГА

Ц.Батболд

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор, дэд профессор

Өнөөгийн Монголын улс төрийн амьдралд улс төрийн намууд ба тэдгээрийн үзэл суртлын чиг баримжааны тухай асуудлууд судлаачдын төдийгүй, олон нийтийн анхаарлыг татаж байна. Тухайлбал, нэг нам нь нэрээ сольж, үзэл баримтлалаа шинээр тодорхойлох зорилт тавьсанаар хагаралдан хуваагдах хандлагатай болж байхад, нөгөө нам нь янз бүрийн үзэл санаанд тулгуурласан олон бүлэглэлийг хүчээр барьж байх зорилго тавьж буй мэт ажиглагдана. Улс төрийн үйл явц дахь уг үзэгдэлд улс төрийн шинжлэх ухааны онолын хүрээнд тоймлосон, тодорхойлт, таамаглал шаардлагатай байна. Орчин үед улс төрийн намуудад үзэл сурталгүйжих, прагматик хандлага, абсентизм үүсэх, онолгүй байх нь өөрөө онол гэх зэрэг хандлага гарах болсон нь зөвхөн Монголд тохиолдож буй асуудал биш, дэлхийн олон улс орнуудад ч түгээмэл үзэгдэж буй хандлага юм.

Энэхүү улс төрийн үзэгдэл, үйл явцын мөн чанарыг авч үзэхийн өмнө ардчилсан нийгэм дэх улс төрийн намын үүрэг, ролийг товч тодотгоё. Орчин үед намуудыг улс төрийн ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн дуу хоолой болох, олон урьгалч үзлийг дэмжих, төр, нийгмийг холбох зуучлагч гүүр болж, засгийн эрхийг аван бодлого зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө тэмцдэг улс төрийн зорилготой иргэний байгууллага гэж үздэг. Дээрх үүргийг гүйцэтгэхээр улс төрийн намууд засгийн эрхийн төлөө олон түмний дэмжлэгийг хүлээхийн тулд өөр, өөрсдийн улс төрийн үзэл суртлын үнэт зүйлст тулгуурласан, тухайн цаг үед тохирсон үзэл баримтлалыг боловсруулан улс төрийн бодлогоо томъёолж, түүнийг хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг сонгогчдын өмнө дэвшүүлдэг. Улс төрийн намуудын үзэл, баримтлал, бодлого, мөрийн хөтөлбөр нь хоорондоо ялгаатай байж, тэдгээрийн аль нэг нь сонгогчдын олонхийн дэмжлэгийг хүлээж, тэдний олонхийн төлөөлөл болсоноор аль нэг нам нь засгийн эрхийг авч бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлж, сонгогч олон түмний өмнө хариуцлагаа хүлээдэг нь ардчилсан засаглалыг хэрэгжүүлдэг механизм юм.

Улс төрийн намуудын хоорондоо ялгаатай байх үндэс нь тэдний үзэл сурталд байдаг. Улс төрийн үзэл суртлын түүхэн үндэс нь эртний Грек, Ром, Хятад, Энэтхэг зэрэг соёл иргэншлийн томоохон төвүүдийн сэтгэгчид (Платон, Аристотель, Цицерон, Кунз, Каутилья), Дундад зууны шашны философичид (А.Августин, Ал Фараби, Аверриос, Аквины Фома, М.Лютер), Сэргэн мандлын үеийн (Н.Макиавелли, Т.Мор, Ж.Боден, Г.Гроции, Б.Спиноза, Т.Гоббс) нарын олон судлаач, сэтгэгчдийн үзэл бодлыг дамжин байж, Сэргэн мандлын болон Соён гэгээрүүлэлтийн эхэн үеэс бүрэлдэн тогтжээ. Эдгээр үеүүдэд Платоны төр засгийн тухай утопи үзэл, Аристотелийн эмпирик харьцуулалт, шашны философичдын бурханаас заяасан жам ёсны ноёрхол зэрэг үзэл санаанууд нь социализм, либерализм, консерватизмын уг сурвалж болжээ. Тэд засаглалын тухай өөр өөрсдийн үзэл санааны үндсийг дэвшүүлж байсан хэдий ч уг үзэл

санаанууд системчлэгдэж, улс төрийн үзэл суртал болж чадаагүй байсан юм. Сэргэн мандлын үеийн сэтгэгчдэд тулгуурласан засаглалын болон хүний жам ёсны эрхийн тухай үзэл санаануудыг Т.Гоббс, Ж.Локк, А.Смит, Э.Бёрк, Ж.Местр, Ж.Ж.Руссо, Г.Бабёф, Ж.Марат нарын олон сэтгэгчидийн өөр өөр байр суурьнаас тайлбарласан шинэлэг үзэл санааг Америкийн тусгаар тогтнол, Францын хөрөнгөтний хувьсгал амьдралд хэрэгжүүлж эхэлсэнээр нийгмийн тодорхой бүлгүүдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор улс төрийн үзэл суртал үүссэн байна.

Улс төрийн үзэл суртал нь өмнөх болон цаг үеийн сэтгэгчдийн онол, сургаал дээр тулгуурласан ертөнцийг үзэх үзлийн систем юм. Энэ үзэл нь тодорхой эрхэмлэх үнэт зүйлс дээр тулгуурладаг. Үнэт зүйлст тулгуурласан үзлээрээ хүмүүс амьдралын үзэл баримтлалаа тодорхойлон, бодлого зорилгоо төлөвлөж үйл ажиллагааныхаа чиг хандлагыг тогтооно. Улс төрийн намын үзэл суртал түүний улс төрийн чиг баримжаа, бодлого зорилго, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг бий болгодог. М.Веберийн үзсэнээр “үзэл суртал бол шинжлэх ухаан дахь шинжлэх ухааны бус хандлага” юм. Өөрөөр хэлбэл, үзэл суртал нь шинжлэх ухаанаар нотлогдоогүй, батлагдаагүй мөрөөдлийн шинжтэй итгэл үнэмшлийн систем байж болох бөгөөд үл гүйцэлдэх шинжийг агуулж байдаг. З.Фрейд үзэл суртлыг төсөөлөл (трансцендент)-ийн шинжтэй хоосон зүйл гэж үзжээ. К.Мангейм түүхийн явцад хүмүүс бодит байдлын зуршлаас илүү трансцендент хүчин зүйлийг баримжаалдаг гэж хүлээн зөвшөөрсөн байна. Гэсэн хэдий ч үзэл суртал шинжлэх ухааны онол, практик мэдлэгт үндсэндээ тулгуурладаг. Тухайлбал, амьдралын явцуу туршлагын хүрээнээс өчүүхэн ч атугай гарч буй үзэл санаа, төсөөллийг үзэл сурталд хамруулах ёстой гэсэн үг юм.

Үзэл суртал нь хүний эрх, эрх чөлөө, улс төрийн эрхээс гадна, эдийн засагт тулгуурлан нийгмийн хөгжлийн ирээдүйн чиг хандлага, хүний ахуй амьдрал, харилцааны үндсийг тодорхойлж байдаг. Орчин үеийн үзэл суртлын чиг хандлагуудыг судлаачид дараах байдлаар тодорхойлж байна.

Энд далайн орнуудын буюу шинээр суурьшсан Атлантизмын үнэмлэхүй төв нь либерал ардчилал байх бөгөөд Евроазийг бодвол, уламжлагдаж ирсэн түүх, соёл, шашин, зан заншил, ёс суртахууны суурь үнэт зүйлс багатай, өөрчлөгдөн шинэчлэгдэгч дэвшлийн шинжтэй гэж үздэг. Евроазийн хувьд олон мянган жилээр уламжлагдаж ирсэн суурь үнэт зүйлсийн нөлөөг даван туулахад бэрхшээлтэй байдаг аж. Гэвч уламжлагдаж ирсэн консерватив үнэт зүйлс нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн олон мянган жилийн туршлагаар баталгаажсан байдаг нь цаг үеийн хувьсал өөрчлөлтийг даван өөрийн мөн чанараа хадгалах чадвартай гэж үздэг байна. Үзэл суртлын эдгээр ерөнхий чиг хандлагууд орчин үеийн нийгэмд улс төрийн намын үзэл баримтлалын олон талт хандлага, прагматик зорилгыг илэрхийлж чадахгүй байна гэж сүүлийн үеийн барууны зарим судлаачид үзэх болсон байна.

Орчин үед үзэл суртлын үнэт зүйлсийг тодруулан гаргахад хэцүү, бараг боломжгүй мэт харагддаг. Янз бүрийн элементээс бүрдсэн хоорондсо олон

талаар холбогддог, тодорхой хязгаарлалтгүй, замбараагүй хэлхээ холбоотой сүлжилдсэн (ризому) тийм үнэт зүйлс шууд нарийн тодорхойлолт өгнө гэдэг бараг боломжгүй санагдана. Гэвч аливаа үзэл суртал бол тодорхой үнэт зүйлс дээр хатуу төвлөрч тулгуурласан иерархи систем байдаг. Өөрөөр хэлбэл, өмнөх үеийн сэтгэгчдийн тодорхойлон гаргасан мөнхийн асуудал мэт цөөн тооны гол үнэт зүйлсэд тулгуурлана гэсэн үг юм. Ихэнх үнэт зүйлс хувирамтгай, тогтворгүй шинж чанартай байдаг. Үүнийг туслах үнэт зүйлс гэж үзэж болно. Гол төвлөрсөн үнэт зүйлсийг тойрон олон төрлийн хувьсамтгай, тогтворгүй болон харьцангуй тогтвортой үйл ажиллагаа явагдана. Энэ нь үзэл суртал, түүний уялдаа холбоог системтэй авч үзэх боломжийг нээж өгдөг. М.Вебер, К.Мангейм, Э.Дюркгейм нар үзэл суртлыг хувь хүнийг болон нийгмийн бүлгийг үйл ажиллагаанд татан оруулах сэдэл болдог субъектив шинжтэй үнэт зүйл гэж үзсэн байна.

Хүснэгт 1. Үзэл суртал, түүний үнэт зүйлсийн ялгаа

Үзэл суртал	Нийгэм	Төр	Улс төр	Эдийн засаг	Хүн	Үйл байдал
Либерализм	Хувь хүмүүс нийгмийг бүрдүүлдэг.	Төр "шөнийн манаач"-ын үүрэгтэй.	Плюраль нийгэм	Эдийн засагт үл оролцох	Хувь хүний хөгжлийг дэмжих	Хувь хүний хариуцлага
Консерватизм	Нийгэм бол жам ёсны харилцаа.	Төр бол бурхнаас заяасан жам ёсны харилцаа.	Нийгэм тэгш бус	Элитүүд эдийн засгийг зохицуулдаг.	Хүн бүр адилгүй	Элитийн нийгмийн хариуцлага
Социализм	Нийгэм бол органик нэгдэл.	Төр "нийтийн сайн сайхан"-ыг хангах ёстой.	Нийгмийн тэгш байдал, шударга ёс	Төр эдийн засгийн харилцааг шударгаар зохицуулах	Бие хүний хөгжлийг дэмжих	Хамтын хариуцлага
Национализм	Нийгэм бол үндэстний оршин тогтнол.	Төр үндэсний эрх ашгийг хамгаална.	Нийгмийн нэгдэл нягтрал	Үндэсний эдийн засгийг бэхжүүлэх, хамгаалах зохицуулалт	Үндэсний ялгаа	Үндэсний ухамсар
Анархизм	Нийгэм чөлөөт хүмүүсээс бүрдэнэ.	Хүмүүс төргүйгээр амьдарч чадна.	Нэгдсэн байр суурьгүй	Нэгдсэн байр суурьгүй	Хувь хүн өөрөө өөрийгөө зохицуулах	Нэгдсэн байр суурьгүй

Үзэл суртал нь анх үүсэхдээ нийгмийн анги бүлгүүдийн эрх ашгийг хамгаалан гарч ирсэн. Эдгээр үзэл суртлуудын үзэл санааны үндсэн цөм нь:

- ✓ Консерватизм. Э.Бёрк, Ж. Местр, Де Бональд. Бурхан, тэнгэрээс заяасан шилдэг хүмүүс нийгмийг удирддаг. Энэ бол бурхны хишиг, байгалийн жам. Хүн бүр адилгүй, нийгэм тэгш бус, түүнтэй эвлэрэх хэрэгтэй. Элит бус хүмүүс нийгмийг удирдвал, нийгмийн хөгжлийн тогтвортой байдал, уламжлал алдагдаж хямрал, тэмцэл, доройтол үүснэ гэж үздэг. Уг үзэл суртал язгууртны эрх ашгийг хамгаалж гарч иржээ.
- ✓ Либерализм. Т.Гоббс, Ж.Локк, Ш.Монтескье. Төр хүний жам ёсны эрхийг хамгаалах ёстой. Үүнд хувийн өмчийг хамаатуулж үздэг. Хувь хүний улс төр, эдийн засгийн эрх чөлөөг хамгийн боломжит дээд хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэмцдэг. Хувь хүний эрх чөлөө нь хувийн өмчийн өсөлтөөр нийгмийн хөгжлийг идэвхжүүлдэг. Хувийн өмчийн харилцаанд

шударга ёсны зарчмийг бус зүй ёсыг баримталдаг. Шинэ хөрөнгөтнүүдийн эрх ашгийг хамгаалж гарч ирсэн.

- ✓ Социализм. К.Маркс, В.И.Ленин, Э.Бернштейн. Язгууртны ноёрхол, өмчийн болон хөдөлмөрийн хөлсний шударга бус байдлыг шүүмжилж гарч ирсэн. Үзэл суртлын гол цөм нь нийгмийн баялагийг шударгаар хуваарилах, нийтийн сайн сайхныг бий болгох явдал. Анх ажилчин ангийн эрх ашгийг хамгаалж гарч ирсэн ажээ.

Хүснэгт 2. Тэгш эрхт ёсыг ойлгох үзэл суртлын тайлбарууд

Хүснэгт 2. Тэгш эрхт ёсыг ойлгох үзэл суртлын тайлбарууд

Үзэл баримтлал	Улс төрийн тэгш ёс	Эдийн засгийн тэгш ёс	Оюун санааны тэгш ёс	Зэрэглэх тэгш ёс
Консерватив	Улс төрийн тэгш ёсыг эсэргүүцдэг. Тэгш ёсноос илүү дэв зэрэглэлийн ёсыг өндөрт тавьдаг. Илүү сайн хариуцлагатай, боловсрол бүхий ангиуд удирдан чиглүүлэх ёстой гэж үздэг.	Эдийн засгийн тэгшитгэх ёсыг эсэргүүцдэг.	Бурхны өмнө бүх хүмүүс оюун санааны тэгш ёстой байхыг дэмждэг. Дэлхий дээрх сүм хийдийн дэв зэрэглэлийн жаягийг сайшаан дэмждэг.	Дэлхий дээрх тэнцүү зэрэглэлийг эсэргүүцдэг. Элит хэсэгт /шалгармал давхрааг/ хүндэтгэлтэй хандах ёсыг дэмждэг.
Либерал	Хуулийн өмнө хүн бүр тэгш байх ёсыг дэмждэг.	Эдийн засгийн урамшууллын тэгш ёсыг эсэргүүцдэг. Эдийн засгийн тэнцүү тааламжтай боломж байх ёсыг дэмждэг.	Хүний оршин тогтнох тэгш ёсыг дэмждэг. Хүн ёс зүйн бүтээл гэдгээрээ бүгд тэнцүү хүндэтгэл хүлээх гавьяатай.	Нийгмийн харилцааны тэгш ёсыг дэмждэг. Элит хэсэгт /шалгармал давхрааг/ хүндэтгэлтэй хандах ёсыг үгүйсгэдэг.
Социал Демократ	Улс төрийн шийдвэр гаргахад хүн бүр оролцох тэгш ёсыг идэвхитэй иргэний үүрэг гэж үзэн дэмждэг. Хуулийн өмнө улс төрийн тэгш ёс байхыг сайшаан дэмждэг.	Эдийн засгийн тэгш тааламжтай нөхцөл боломж нь өөрийгөө хөгжүүлэх чадвар гэж үзэн тэрхүү тэнцүү тааламжтай боломж байхыг дэмждэг. Бүх хүмүүст тэгшитгэсэн тэнцүү орлого хуваарилах, мөн баялгийн асар их ялгаатай байх ёсыг эсэргүүцдэг.	Хүмүүнлэг, үнэт зүйлсийн чанараараа бүх хүмүүс тэнцүү хэмээх ойлголтыг дэмждэг.	Нийгмийн харилцааны тэгш ёсыг дэмждэг. Давуу эрх бүхий элит хэсэгт /шалгармал давхрааг/ хүндэтгэлтэй хандах ёсыг үгүйсгэдэг.
Коммунист	Улс төрийн тэгш ёсыг эсэргүүцдэг. Арми цэргийн адил үүрэг бүхий манлайлагч намын удирдлагатай байхыг сайшаан дэмждэг. Нийтээрээ улс төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг хангагч олон нийтийн байгууллагыг намаас хянадаг.	Орлогыг туйлын тэнцүү байлгах төрийн бодлогыг дэмждэг. Социализмын үе шатны хугацаанд эд баялгийн урамшуулал нь ажиллах дэм үүрэг гэдэг утгаараа тэгш бус цалингийн орлогыг сайшаан дэмждэг. Бүрэн коммунизмын үе шат хүртэл эдийн засгийн бодитой тэгш ёс бий болохгүй гэж үздэг.	Сайн хүмүүс /пролетари нар, ядуу тариачид, мөлжигдөгч анги, намын боловсон хүчин/ болон муу хүмүүсийн /хөрөнгөтөн, газрын эзэд, мөлжигчид, намын эсрэг бүлгийнхэн/ хооронд оюун санааны тэгш ёс байхыг эсэргүүцдэг.	Зэрэглэлийн тэгш ёсыг, ялангуяа пролетари нар, ядуу тариачид, эмэгтэйчүүд болон ястны цөөнхи бүлгийг дээгүүр тавих ёсыг дэмждэг. Бүх ард түмэн ажилчин анги болох ойлгоцыг өндөрт тавьдаг.
Фашист	Улс төрийн тэгш ёсыг эсэргүүцдэг. Нийгэм бол шалгармал хэсэг /элит/ болон аугаа их хошуучлагчаар удирдуулсан нэгэн организм /биет/ юм. Намын болон төрийн үүрэг нь арми цэргийн адил.	Эдийн засгийн урамшууллын тэгш ёсыг үгүйсгэдэг. Гэхдээ эд баялаг нэмэгдэх тэнцүү тааламжтай боломжийг сайшаан дэмждэг.	"Дээд" арий гаралтан болон "доод" еврей нарын хооронд оюун санааны тэгш ёс байхыг эсэргүүцдэг.	Арий гаралтай эрэгтэйчүүд болон бусад "доод" бүлгийнхний хооронд зэрэглэлийн тэгш ёс байхыг эсэргүүцдэг. Аугаа их удирдагчид илүү хүндэтгэлтэй байх ёсыг дэмждэг.

Нийгмийн гишүүд буюу хувь хүмүүс янз бүрийн үзэл бодолтой байх бөгөөд ямар ч хувь хүн үндсэн үзэл суртлуудын мөн чанарыг бүгдийг өөртөө агүүлж

Нийгмийн гишүүд буюу хувь хүмүүс янз бүрийн үзэл бодолтой байх бөгөөд ямар ч хувь хүн үндсэн үзэл суртлуудын мөн чанарыг бүгдийг өөртөө агүүлж

байдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүн сэтгэл судлаачдын нэрлэдэг дөрвөн темпераментыг бүгдийг ямар нэг хэмжээгээр өөртөө агуулна. Аль нэг темперамент давамгайлсанаар нь хүнийг тийм темпераменттэй гэдэг. Харин зөвхөн нэг темпераменттэй хүн бараг байдаггүй. Хэрэв тийм шинж ихтэй бол шизопрентэй хүн гэж үздэг. Үүний нэг адил хувь хүмүүсийн үзэл бодол аль нэг үзэл суртлын үнэт зүйлсийг илүү дэмждэг. Харин нэг үзэл сурталд туйлшрах нь тухайн үзэл санааг хөгжүүлэхэд тус дөхөм болдог. Гэхдээ хэт туйлшрал буюу нэг үзэл суртлын хэт ноёрхол нь нийгмийг гажуудуулдаг байна.


Хүснэгт 3. Нийгмийн бүлгүүд ба үзэл суртал

Намуудын үзэл суртал	Либерализм	Консерватизм	Социализм	Национализм	Анархизм
Хувь хүн	Аминч үзэл	Уламжлалт үзэл	Хамтын үзэл	Үндэсний үзэл	Өөрийнхөөрөө байх үзэл
Нийгмийн анги, бүлгүүд	Дунд анги	Дээд анги	Доод анги	Дээд, дунд, доод	Дээд, дунд, доод

Хувь хүн ямар үзэл баримтлалыг илүү баримтлах вэ гэдэг нь түүний нийгэмд эзлэх байр суурь, хаана ямар түвшинд амьдарч байгаатай илүү холбогддог. Тухайлбал, нийгмийн давхраажилтын дээд хэсэгт байгаа хүмүүс тухайн нийгмийн үнэт зүйлсийг хадгалж хамгаалсанаар өөрийн эрх ашиг, байр сууриа хамгаалдаг. Үүний мөн чанарыг өөрөөр хэлбэл, элитийн нийгмийн хариуцлага, хариу нэхээгүй тус гэх мэтээр илэрдэг. Дунд хэсэгт байгаа хүмүүс аж амьдрал, эдийн засгаа сайжруулж дээд түвшинд хүрэхийн тулд хууль ёс, шударга өрсөлдөөнийг шаардаж байдаг. Мөн чанар нь өөрөөр хэлбэл, “Тамирын мөсийг долоох шахаж олсон хөрөнгийг хүнд зүгээр өгч болохгүй” гэх мэт. Харин доод хэсэгт байгаа хүмүүс амьдралын бэрхшээлийг даван туулахын тулд бие биедээ туслан хамтын сэтгэлгээг илүү хөгжүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, “миний юм чинийх, чиний юм минийх... , нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө” гэх мэт.

Хувь хүмүүсийн үнэт зүйлсийн сэтгэлгээний онцлог нь философийн ухамсар ба матер гэсэн дилемма (ац)-ээр ялгагддаг. Хувь хүмүүсийн үнэт зүйлсийн системийг авч үзсэн Маслоугийн хэрэгцээний шатлал нь материалист тайлбар юм. Уг тайлбар массын сонирхол, эрх ашиг, амьдралын түвшнийг илэрхийлдэг. Анхдагч хэрэгцээгээ хангаагүй масс социал үнэт зүйлсийг эрхэмлэдэг. Өөрөөр хэлбэл, нийгмийн доод давхрагынхан олон байвал, социалист, социал демократ үзэл суртлын хэрэгцээ, шаардлага, дэмжлэг хүчтэй байдаг.


Зураг 1. Маслоугийн хэрэгцээний шатлал.



Материализм

Социалист үнэт зүйлсийн систем нь халамжийн төр биш юм. Ийм төөрөгдөл барууны ихэнх зохиолд ноёрхдог. Тэд социализмд амьдарч үзээгүй учраас төөрөгддөг байж болох юм. Социализм бол хамтын амьдралын систем бөгөөд хамтын хариуцлагад тулгуурладаг. Нийтийн эрх ашиг хувийн эрх ашгийг хязгаарладаг. Хамтын хариуцлага, хамт олны ёс суртахуун хувь хүнийг маш хүчтэй шахдаг. Муу ажиллаж, муу амьдарч байгаа хүнийг элдэв тэтгэмжээр харж үздэг тогтолцоо социализмд байхгүй. Харин түүнд тохирсон ажлаар хангаж, ажиллахыг шаардан, хамтын баялагаас хүртэхийг зөвшөөрдөг. Халамжийн төрийн тогтолцоо бол консерватизмын мөн чанартай нийцдэг. Эртний Египет, Вавилон, Грек, Ром, Хятад, Энэтхэгт ч төдийгүй Монголд ч дээдэс нь доодсоо халамжилдаг хэлбэр, номлол байсан бөгөөд өнөөгийнх шиг төрийн тогтолцоо болж институцсэн хэлбэрээр хөгжөөгүй байсан билээ.

Зураг 2. Маслоугийн хэрэгцээний шатлалыг эсрэг тайлбар.



Идеализм

Ухамсар анхдагч хэмээх тайлбарт сонирхол, эрх ашиг, амьдралын түвшнийг илэрхийлдэг. Нийгмийн хөгжлийн явцад дээд, дунд анги, тэдгээрт шилжих хувь хүн, бүлгүүдийн тоо өсөхөд нийгмийн социал ялгаа буурна. Иймээс

дунд ангийн тоо өсч, либерал, неоконсерватив үнэт зүйлсийг дэмжих хандлага ихэснэ. Гэхдээ капитализмын мөн чанар нь хүмүүст баялагийг бүтээж амьдралаа дээшлүүлэхийг хатуу шаардаж байдаг. Өөрөөр хэлбэл, мөнгө түүнийг олох, хэрэглэх явдал хүний хувийн хариуцлагыг нэмэгдүүлдэг. Эртний цаг үеүүдэд идеализмийн чиглэлээр цөөнх замнадаг байсан бол, эдүгээ бүх нийтийн боловсролын тогтолцооны хөгжил, амьжиргааны түвшин, мэдээллийн системийн өсөлт ихэнх хүмүүсийг ийм зам руу чиглүүлэх болсон. Өөрөөр хэлбэл, орчин үеийн нийгэмд боловсрол олж авч, өөрийгөө хөгжүүлэхгүй бол амьдрахад хэцүү гэдгийг ихэнх хүмүүс ойлгох болжээ. Ийм нөхцөлд либерализмыг дэмжих хандлага ихэснэ.

Нийгмийн давхраажилтад дээрх хандлагууд холилдон орших бөгөөд давхраажлын талаарх К.Марксын ангийн хандлагыг М.Вебер шинэчлэн хөгжүүлсэн юм. Вебер, эдийн засгийн бодит нөхцөл ба ангийн хоорондын хамаарлын талаарх Марксын төсөөллийг хүлээн зөвшөөрөхийн хамт, харин анги бүрэлдэхэд Марксын ажигласнаас илүү олон хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзжээ. Веберийнхээр бол ангиудад хуваагдах нь зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмшиж буй эсэхээр тодорхойлогддоггүй, өмчтэй шууд холбоогүй эдийн засгийн ялгаагаар бас тодорхойлогдоно. Ийм тодорхойлогч хүчин зүйлийн тоонд юуны өмнө тухайн хүний ямар нэг ажил гүйцэтгэх чадварт нөлөөлдөг ур чадвар, мэргэжил ордог гэж үзсэн. “Вебер, ангийн зэрэгцээ давхраажлын өөр хоёр чухал талыг ялган үзсэн байна. Түүнийхээ нэгийг статус нөгөөг нь нам хэмээн нэрлэсэн байна”¹⁰⁵. Анги нь өмч хөрөнгө, ашиг орлого гэх мэт эдийн засгийн хүчин зүйлстэй холбоотой байдаг бол статус нь тухайн бүлгийн хүмүүсийн ялгаа бүхий аж төрөх ёсоор тодорхойлогдоно. Орчин үеийн нийгэмд засаглалын нэг чухал хэрэгсэл нь нам байдаг бөгөөд тэрээр анги болон статусаас үл хамааран давхраажилд нөлөөлж байдаг хэмээн Вебер үзжээ. Нийтлэг эх сурвалж, зорилго, ашиг сонирхолтой, хамтран ажилладаг бүлэг хүмүүсийг нам хэмээн тодорхойлж болно. Тэрээр Марксын ангийн тухай ойлголтыг ашиглан янз бүрийн статус болон намуудын үүслийг тайлбарлажээ.

Эртний сэтгэгчдийн үзэл санаануудад тулгуурласан үзэл суртлын чиг баримжаанууд нь улс төрийн намуудын үүсэл хөгжлийн үндэс болсон юм. Үзэл суртлын үүслийн түүхийг товч авч үзвэл:

- ✓ Либерал чиг баримжаатай намууд XVII - XVIII зуунд шинээр төрсөн хөрөнгөтөн, дунд ангийн эрх, нийгэмд эзлэх байр суурь, ашиг сонирхлыг хамгаалахаар дугуйлан (котери), клуб хэлбэрээр үүсэн зохион байгуулагдаж, парламентад “хүч түрэн”¹⁰⁶ орж иржээ.
- ✓ Консерватив чиг баримжаатай намууд парламентад угсаа залгамжилсан язгууртны эрх ашгийг хамгаалахаар дугуйлан (котери) хэлбэрээр үүсэн зохион байгуулагдсан байна.

¹⁰⁵ А.Гидденс. Социологи. УБ., 2006. Х 167-169.

¹⁰⁶ Размышления о революции во Франции. London: Overseas Publications Interchange Ltd, 1992 (то же: М.: Рудомино, 1993)

- ✓ Коммунист, социалист чиг баримжаатай намууд Якобинчуудыг эс тооцвол, XIX зуунд сонгуулийн эрх чөлөө бий болсонтой хамт олон түмний намын хэлбэрээр парламентын гадна үүсжээ.

Ажилчин ангийн дэмжлэгийг хүлээсэн "массын намын түрэлт"¹⁰⁷ Европ дахь "либерал болон консерватив намуудыг массын намын нөмөрт хоргодоход хүргэсэн"¹⁰⁸ байна. Энэ нөхцөлд консерватив намууд шашин ба үндэсний үзлийг, либерал намууд ҮЭ-ийг ашиглан гишүүнчлэлээ өргөжүүлсэн байна.

Улс төрийн намын хөгжил нь нийгмийн давхраажилт, тэдгээрийн анги, бүлгүүдийн болон техник технологийн хувьсал өөрчлөлттэй холбоотой явагдаж ирсэн байна. Уг өөрчлөлтийг М.Вебер хэдийгээр ангийн тодорхой нөлөө илэрхий байгаа ч гэсэн статус бүрэлдэх, намууд үүсэхийг зөвхөн ангийн үзлийн байр сууринаас тайлбарлаж болохгүй гэж үзжээ. Өөрчлөлт нь нийгмийн статус, намын харьяалалаар тодорхой хүмүүс болон бүлгийн амьдралын эдийн засгийн нөхцлөөр тодорхойлогдох төдийгүй, энэ нь ангиудад ч гэсэн бодитой нөлөөг үзүүлдэг байна. А.Гидденс "намууд нь ангийн ялгаанаас тэс хөндлөн сэтгэл хөдлөлийн байдалд хүргэж болох ба жишээлбэл, намууд үндсэрхэг үзлийн юм уу, шашин шүтлэгийн ялгаан дээр ч байгуулагдаж болно."¹⁰⁹ гэж үзэж байсан.

Э.Райт өнөөгийн капиталист үйлдвэрлэлд буй үндсэн ангиудыг тодорхойлох боломжийг олгодог эдийн засгийн нөөц баялгийг хянах үндсэн гурван хэлбэр буй бөгөөд тэдгээр нь капиталист нийгэмд оршин буй үндсэн ангиудыг ялган тодорхойлох боломжийг олгодог гэж үзжээ. Үүнд:

1. Хөрөнгө оруулалт ба мөнгө санхүүгийн капиталд тавих хяналт
2. Үйлдвэрлэлийн биет хэрэгслүүдэд (газар, үйлдвэр, албан тасалгаа) тавих хяналт
3. Ажиллах хүч ба засаглалд тавих хяналтыг авч үзсэн байна.

Үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэгч эдгээр гурван зүйлийн ядаж нэгийг нь хүн амын хөрөнгөтний ангид хамрагдах тэр хэсгийнхэн хянаж байдаг. Ажилчин анги хяналт тавих ямар ч боломжгүй. Гэвч эдгээр чухал ангиудын зэрэгцээгээр байр суурь нь тодорхойгүй бүлгүүд байдаг. Эдгээр хүмүүсийг Райт ангийн зөрчилтэй байр суурьтай хэмээн тодорхойлжээ. Тэд үйлдвэрлэлд зарим талаараа нөлөөлөх чадвартай боловч, заримд нь хяналт тавих эрхээр хязгаарлагдмал байдаг. Тухайлбал, оюуны хөдөлмөр эрхлэгчид буюу «цагаан захтнууд» жирийн ажилчдын нэг адил ажиллах хүчээ үйлдвэрийн эздэд худалддаг. Гэхдээ тэд ажилчдыг бодвол хөдөлмөрийнхөө нөхцөлийг ихэнх тохиолдолд өөрсдөө хянаж чаддаг аж. Ийм ажилтнуудын байр суурийг Райт «зөрчилдөөнтэй» гэж нэрлэжээ. Учир нь тэд ангийн харьяаллаараа хөрөнгөтөн ч биш, ажилчин ч биш боловч эдгээр хоёр ангийн аль алинтай нь төстэй шинжийг агуулсан байдаг аж. Ф.Паркин өмч нь нийгмийн цөөнх хэсэг монопольчилж, эрх мэдэлд хүрэхдээ ашигладаг социал саадын нэг гэж үзсэн байна. Социал саад бий болохыг үйл явц гэж үзэж болох бөгөөд үүний үр дүнд бүлгүүд нөөц баялгийг зөвхөн өөрөө хянах, бусдын боломжийг хязгаарлах гэж оролддог байна. Веберийнхээр социал

¹⁰⁷ М.Дюверже. Политические партии. Пер Зимины Л.И. 2000. <http://www.yandex.ru>

¹⁰⁸ Ла Паломбара, Ж.Сартори. Политические партии. <http://www.sibupk.nsk.su>

¹⁰⁹ А.Гидденс. Социологи. УБ., 2006. X 167-169.

саад бий болгоход үйлдвэрлэлийн хэрэгслийн баялаг болон өмчөөс гадна угсаатны хамаарал, хэл, шашин зэрэг статусын ялгааг ашиглаж болдог байна.

Нийгмийн хөгжлийн явцад анги бүлгүүдийн социал ялгаа буурч, давхраажилтын хооронд шилжих хүмүүсийн шилжилт чөлөөтэй буюу өөрсдөөс нь шалтгаалах болсноор үзэл суртлын үнэт зүйлсд шилжилт өөрчлөлт, давхцал гарах болсон байна. Тухайлбал, 1929-1933 оны эдийн засгийн хямрал Кэйнсын онол, неолиберализмыг, 1973-1974 оны нефтийн (эрчим хүчний) хямрал төрийн менежмент, неоконсерватизмын онол, үзэл баримтлалыг төрүүлжээ.

Чөлөөт зах зээлийн "Их хямрал"¹¹⁰-ыг зохицуулах амлалтууд өгч улс төрийн намууд төрд хүчтэйгээр орж ирсэнээр сонгодог либерал үзлийн эсрэг Ж.Кэйнсийн "төрийн зохицуулалттай зах зээл"-ийн онолыг баримтласан неолиберализмын урсгал гарч ирсэн юм. Тухайлбал, "засгийн газраас эдийн засагт оролцох шаардлагагүй бөгөөд зах зээл нь урт хугацаанд бүрэн ажил эрхлэлтийг бий болгож, эдийн засгийг өөрөө сэргээдэг гэдэг либерал үзлийг Кейнс дүгнэж энэ янзаараа явбал алсын төлөвтөө бид бүгд мөхөх аюултай юм"¹¹¹ гэж шүүмжлэсэн байна.

Ийнхүү нийтийн эрх ашиг нэрийн дор төр хүч хэрэглэн зохицуулахыг зөвтгөсөн социализмын чиг баримжааг неолиберализм баримтлах болжээ. "Хямралыг зохицуулах амлалтууд нь неолиберализм, национал-социализм, коммунизм зэрэг шинэ үзэл суртлыг төрүүлэн, баруун зүүний тоталитаризмыг идэвхжүүлсэнээр улс төрийн намууд төрийн бүх салаа салбарт ноёрхох болж төрийн удирдлагыг улс төрийн бюрократ гэдэг шинэ хэлбэрт шилжүүлэв. Улс төрийн бюрократ нь төрийн чадвар, автономи, төвийг сахих шинжийг үгүй хийж, намын үзэл суртлын зохицуулалтыг хүчтэй болгон, гадаад, дотоод улс төр болон эдийн засгийн хямралыг даван туулахад нийгмийн бүх гишүүдийг дайчлах болсон билээ"¹¹².

1970-аад оны нефтийн (эрчим хүчний) хямралаар неолиберал үзэл суртал төрийн оролцоог ихэсгэж, зүүний үзэл баримтлалыг авах болсон гэж шүүмжлэгдэж, үүний эсрэг сонгодог либерал үнэт зүйлсийн заримыг сэргээн авах маягаар консерватив үзэл суртал шинэчлэгдэн неоконсерватизм гарч иржээ. Неоконсерватив үзэл суртал төрийн оролцоог хязгаарлах, төрийн өмчийг хувьчлах, үр ашигтай цомхон, хүчтэй төрийн тухай үзэл баримтлалыг тунхаглан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх болсон байна. Шүүмжлэгдсэн неолиберал үзэл сонгодог либерал үзлийн суурин дээр дахин шинэчлэгдэж, анархизмын өнгө аясыг агуулсан либертарианизм болон ХХ зууны эцсээр гарч иржээ.

Үзэл суртлын давхцал болон өөрчлөлтөөс хамаарч "орчин үеийн хөгжингүй нийгэмд анги нь өөрийн учир холбогдлоо алдсан хэмээн зарим эрдэмтэд үзэж байна. Тэд бүтэн хагас зууны тэртээ аж үйлдвэрийн капитализм үүсч байх тэр үед ангийн ялгаа онцгой утга агуулгатай байсан гэдэгтэй тэд санал нийлдэг. Түүнчлэн Марксын онолд хамгийн их шүүмжлэлтэйгээр ханддаг хүмүүс хүртэл ядуу хөдөлмөрчид болон ажил олгогч баячууд, үйлдвэрийн эздийн

¹¹⁰ 1929-1933 оны их хямрал.

¹¹¹ Ж.Штиглиц, Тогтвортой өсөлтөнд хүрэхийн тулд Зүүний үзлийг дага. Орч Д.Бадамдаш. <http://www.openforum.mn>

¹¹² Ц.Ганболд, Ц.Батболд. Төрийн удирдлагын хөгжлийн түүхэн үе шатууд. /Төрийн захиргаа сэтгүүл/ 2010 № 01(11).

хооронд жигшмээр зөрчилдөөн бодитойгоор оршин байсныг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ тэр цагаас хойш үйлдвэржсэн орнуудад материаллаг тэгш бус байдал ихээхэн багассан. Баячуудын эсрэг чиглэсэн татварыг ядуу болон хөдөлмөрийн чадваргүй хүмүүст олгох тэтгэмжтэй хослуулснаар дээдэс доодсын хоорондох ялгааг багасгасан. Түүнээс гадна боловсрол нийтэд хүртээмжтэй болсноор авъяас чадвартай хэн бүхний өмнө нийгмийн болон эдийн засгийн шатлалын оргилд хүрэх зам нээлттэй болсон хэмээн нотолж байна. Үүнийг Гидденс "үнэндээ дээрх дүр зураг үнэн байдалтай огт нийцэхгүй. Ангийн ялгааны нөлөөлөл Марксын бодож байснаас арай багассан байж болох боловч, социал амьдралын тун цөөхөн хүрээ л түүнд хөндөгдөлгүй үлдсэн"¹¹³ гэж шүүмжилсэн байдаг.

Орчин үеийн улс төрийн намуудын үзэл баримтлалын хандлага үзэл суртлын үнэт зүйлсийг хатуу баримтлахын оронд тухайн нөхцөлд тохируулан үзэл баримтлалаа тодорхойлох болсон байна. Г.Шелдон "Т.Жефферсоны улс төрийн философи" гэдэг номондоо Жефферсон либерал ба бүгд найрамдахчуудын үзлийн алийг нь илүү баримталж байсан бэ гэдэгт судалгаа хийжээ. Тухайн номд дурдагдсан түүхэн баримтуудад тулгуурлавал Жефферсон либерал үнэт зүйлсд илүү ханддаг байсан нь харагддаг хэдий ч тухайн нөхцөл байдалд консерватив үнэт зүйлсийг илүү баримтлан шийдвэр гаргадаг байжээ. Энэ нь үзэл суртлын үнэт зүйлс ба үзэл баримтлалын хоорондох ялгааг харуулж буй баримт юм. Өөрөөр хэлбэл, тухайн үзэл суртлын үнэт зүйлсийг дэмждэг хэдий ч нөхцөл байдалд тохируулан өөр үнэт зүйлсийг сонгон авч хэрэгжүүлэх явдал бол тодорхой цаг хугацааны хувьд үзэл баримтлал, хандлагаа тодорхойлж буй үйл явц буюу прагматик хандлага юм.

Прагматик номлол бол оюун ухааны хийсвэр тогтолцоо бус, харин хүмүүсийн амьдралын бодит нөхцөлийг зохистойгоор шинэчилж, хийсвэр ойлголтуудыг авч үзэхийн оронд хүнд хэрэгтэй бодит зүйлсэд анхаарлаа хандуулах нь зүйтэй хэмээн үздэг. Энэ утгаараа прагматизм нь улс төрийн бодлогын харьцангуй зарчмыг баримталж, номолдог. Өөрөөр хэлбэл, амьдралд өргөн хүрээтэй чухал бодлогыг ард иргэд хүмүүст ойр дөт хүргэн ойртуулахын тулд боломжтой бүх сувгаар улс төрийн шийдвэр гаргах бүх хүрээнд ажилуулна гэсэн үг юм. Хувь хүний болон ард иргэдийн амьдралд ойр биш, тэднээс тасархай бодлого бол улс төрийн бодлого бус юм. Улс төрийн бодлогыг субъектээс субъектийн хооронд хийх ёстой. Ийм учраас хүн бол улс төрийн субъект мөн гэж прагматизм үздэг.

Орчин үеийн улс төрийн намуудын үзэл баримтлал дараах хүчин зүйлстэй илүү холбоотойгоор прагматик хандлагыг баримтлах явдал түгээмэл байна.


Үүнд: Нэгд. Дундаж сонгогчдын хүсэл, сонирхлыг харгалзан үзэх; Хоёрт. Ардчилалын ерөнхий үнэт зүйлсийг харгалзан үзэх явдал аль ч улс төрийн намуудад чухлаар тавигдаж байна. Гуравт. Үндэсний сэргэн мандлын төлөөх

¹¹³ А.Гидденс. Социологи. УБ., 2006. Х 167-169.

зорилго нь улс төрийн намуудыг зарим тодорхой нөхцөл байдлын хүчин зүйлсүүдийг хүлээн зөвшөөрөхөд хүргэснээрээ хоорондоо үзэл баримтлалын хувьд адилсуулдаг байна. Дөрөвт. Глобальчлал, мэдээллийн зууны эрин үед улс төрийн намууд олон улсын эрх зүй, түүний хууль дүрмүүд, мэдээллийн давалгааг хүлээн авах, зохицуулах, даван туулах улс орны эрх ашиг, үндэстний оршин тогтнолын үүднээс нэгдмэл байр суурь баримтлахад хүргэж байна. Тавд. Дэлхий даяарх эдийн засгийн либералчлал, зах зээлийн өрсөлдөөнд нэг хэсэг улс орнууд давуу байр сууриа хадгалах, нөгөө хэсэг нь тэдний хэмжээнд очихын тулд эрчимтэй зохицуулалт хийх, гурав дахь хэсэг нь дэлхийн зах зээлд өөрийн байр сууриа олох, тогтоох зорилго тавьж байгаа нь тэдгээр орнуудын улс төрийн намуудын үзэл баримтлалыг тодорхой нэг чиглэлд төвлөрүүлэх хэрэгцээг бий болгож байна. Зургаад. Нийгмийн социал ялгаралт багасаж буй байдал. Долоод. Дэлхийн эдийн засгийн нөөц баялагийг эзэмшиж буй үзүүлэлт. Энэ нь тухайн орны улс төрийн намуудыг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд зохицуулалт хийх бодлогоор дамжуулан үзэл баримтлалыг ойртуулж байна. Наймд. Намууд улс төрийн үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрөө шинжлэх ухаанч болон рационал хандлагад тулгуурлан боловсруулах явдал үзэл бодлын ялгааг бууруулж байна.


Дээрх хүчин зүйлсийг тус бүрд нь загварчилсан зураг дүрсээр харуулбал, илүү тодорхой болно.

Зураг 3. Дундаж сонгогчид руу чиглэсэн хандлага



Ардчилсан дэглэмтэй ихэнх улс оронд ерөнхийдөө сонгогчдын хоёр туйл, хоёр намын ээлжилсэн ноёрхол тогтох нь түгээмэл байна. Сонгогчдын 40-50 хувь нь ойролцоогоор 20-25 хувийн бага зэргийн хэлбэлзлэлтэйгээр хоёр туйлд тэнцүү шахуу хуваагддаг. Ийм нөхцөлд намуудын улс төрийн үзэл баримтлалын чиг баримжаа дундаж сонгогчидын хүсэл сонирхлыг хангахад чиглэсэн улс төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх хандлагатай байдаг нь тэдний үзэл баримтлалын ялгааг бүдгэрүүлж, хоорондоо ялгагдах шинж чанарыг нь багасгадаг байна.


Зураг 4. Ардчиллын ерөнхий үнэт зүйлсийг тойрсон үзэл баримтлалууд



Эх сурвалж: http://www.sibupk.nsk.su/New/04/chairs/c_history/Politologsh

Ардчилал гэдгийг А.Линкольн "Ард түмний төлөөх, ард түмний байгуулсан, ард түмний засаглал" гэж тодорхойлсон бол, М.Вебер "Ардчилал бол ард түмний засаглалыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл" гэж тодорхойлсон байдаг. Ардчилсан дэглэмтэй улс оронд ардчилсан засаглалын ерөнхий үнэт зүйлсийг улс төрийн бүх намууд хүлээн зөвшөөрч түүнийг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Гэвч ардчиллын ерөнхий үнэт зүйлсийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, механизмын хувьд намууд өөр өөрсдийн үзэл баримтлал, хандлагаар зөрчилдөх нь зайлшгүй бөгөөд үүнд л ардчилсан улс төрийн институцийн мөн чанар оршиж, тэдний сонирхлыг хэлэлцүүлэх, тэнцвэржүүлэх, зөвшилцүүлэхэд чиглэгддэг. Чухам энд л засаглал болон захиргааны институцийн тогтолцооны зөрчил, зөвшилцлийг иргэний нийгмийн тусламжтайгаар шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай тулгардаг байна. Гэхдээ ардчилсан засаглалын болон захиргааны институцийг зохистой тогтоох зорилго нь улс төрийн намуудын үзэл баримтлалыг хоорондоо ялгаатай ч нэг чиглэлд хандуулж байна.

Зураг 5. Даяаршил ба үндэсний эрх ашгийн хүчин зүйлст тулгуурласан үзэл баримтлалын нэгдэл



Өнөөгийн ертөнцөд ямар ч улс орон, бусад улс орнуудтай нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, байгал орчин зэрэг олон талын харилцан хамааралтайгаар оршин тогтож, хөгжих нь улам зайлшгүй болсоор байгаа нөхцөлд тухайн улс орны үндэсний эрх ашиг, аюулгүй байдлын асуудлууд, тэдгээрийн улс төрийн намуудын үзэл баримтлалыг уг чиглэлд нэгдсэн байр суурь руу илүү ойртуулж байна.

Зураг 6. Нийгмийн социал ялгаралт багасаж буй байдал



Ардчилал бэхэжсэн улс орнуудад нийгмийн олонхийг дунд давхрага эзлэх болсон нь нийгмийн бүлгүүдийн социал ялгарлыг багасгаж, улс төрийн намуудыг уг даврагад хандсан үзэл баримтлал бүхий бодлого боловсруулахад түлхэж буй нь үзэл баримтлалын ялгааг багасгахад нөлөөлж байна.

Зураг 7. Дэлхийн эдийн засгийн нөөц баялагийг эзэмшиж буй үзүүлэлт



Хөгжингүй капиталист орнууд: 20 гаруй улс
Хагас хөгжилтэй орнууд: 70 гаруй улс
Буурай хөгжилтэй орнууд: 140 гаруй улс


К.Марксын "Капитал"-д даяар капитализмын мөн чанарыг дээрх байдлаар "үйлдвэрлэлийн хэрэгслэлийг өмчилсөн мөлжлөгийн хэлбэр" хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, тэрээр иерархийн дээр буй хөгжингүй улс орнууд доод хоёр шатны улсуудыг, дунд шатных нь доод шатаа цэрэг-улс төр, эдийн засгийн аргаар мөлждөг гэж үзжээ. Тухайн цаг үед олон улсын эрх зүйн өнөөгийн түвшин байгаагүй, колонийн систем ноёрхож, "хүчтэний зөв, хүчгүйн буруу" гэдэг хууль олон улсын дэг журамд үйлчилж байсан зэрэг нь уг дүгнэлтэд

хүргэхэд нөлөөлсөн. Гэвч орчин үед ийм шинж чанар харьцангуй буурсан бөгөөд бүрэн үгүй болсон гэж үзэх үндэсгүй юм. Энэ нөхцөл Тухайн улс орнуудын эдийн засгийн ашиг сонирхол тэдгээрийн улс төрийн намуудын үзэл баримтлалыг нэг шугаманд аваачих үндэслэл болно.

Намууд улс төрийн үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрөө шинжлэх ухаанч болон рационал хандлагад тулгуурлан боловсруулах явдал үзэл бодлын ялгааг бууруулж байна. Намуудын бодлого, зорилго, мөрийн хөтөлбөр улс орнуудад улам шинжлэх ухааны онол арга зүй, тооцоо судалгаанд тулгуурлах болсон нь бодит нөхцөл байдлыг зөв үнэлэх, илүү оновчтой буюу рационал хандлага руу тэмүүлэх байдлаар үзэл баримтлалын ойртолт явагдаж байна.

Дээрх хүчин зүйлсүүд улс төрийн намуудын үзэл баримтлалыг улс орныг удирдахад илүүтэй чиглэгдэж буйг илэрхийлж байгаа нь улс төрийн намын хөгжлийг “catch all” ба “картель” намуудын хэв маяг руу чиглүүлсэн ажээ. “Catch all” ба “картель” намууд нь нийгмийн хэсэг бүлэг, аль нэг социал давхрагын эрх ашгийг хангахыг эрмэлзэхээс татгалзаж, нийгмийн бүх давхрагын эрх ашгийг зохицуулах “өргөн хүрээтэй бодлого” (catch all намын мөн чанарын нэг)-ыг өөр өөрсдийн үзэл суртлын үнэт зүйлст тулгуурлан боловсруулахад бусад намуудын үзэл бодлыг “харгалзан үзэж зохицуулах”(картель намын мөн чанарын нэг)-ыг илүүд үзэх болжээ. Улс төрийн намуудын үзэл суртлын үнэт зүйлс ба баримталж буй чиг баримжааг доорх зургаар тоймлон үзүүлэв.

Зураг 8. Улс төрийн үзэл суртлын харьцуулалтын дөрвөн бинар



Эх сурвалж: Ц.Батболд. Улс төрийн шинжлэх ухаанд загварчлалын аргыг хэрэглэх нь. 2010. ЭШ-ний илтгэл.

Улс төрийн үзэл суртлын харьцуулалтын дөрвөн бинар (шууд ба дан байдлаар)-ыг аналоги загварчлалаар авч үзэв. Үүнд: үзэл суртлуудын төсөөтэй талуудын давхцыг загварчлан харуулсанаар тэдгээрийн талаарх ойлголт илүү тодорхой харагдана. Тухайлбал, босоо шугамын дээд талд социал-демократ ба либерал үзэл суртлууд удирдлагыг төвлөрсөн бус болгож, хэвтээ удирдлагад шилжүүлэх тал дээр НӨУЁБ ба иргэний нийгмийн бие даасан хүрээний бодлогоор ойртож, зүүн, барууны төв үзэл гэж нэрлэгддэг. Харин босоо шугамын доод талд удирдлагын төвлөрөл ба хариуцлагын асуудал яригдах бөгөөд коммунистууд нийтийн эрх ашгийн үүднээс хариуцлага хүлээхийг, консервативчууд элитийн нийгмийн хариуцлагыг тус тус төвлөрсөн удирдлагаар шийдвэрлэхийг хүсдэг. Энд удирдлагын хэт зохицуулалт ба зохицуулалтыг хязгаарлах хоёр туйл байдгийг үзэл суртлын зүүн, баруун туйл гэж үздэг. Хэвтээ шугам өмчийн талаарх үзэл суртлуудын үнэт зүйлсийн чиг баримжааг илэрхийлнэ. Гэвч эдгээр үзэл суртлууд нь ардчиллын ерөнхий үнэт зүйлсийн хүрээнд улс төрийн намуудыг прагматик хандлага руу чиглүүлдэг байна.

Ч.Пирс “Ойлголтын ач холбогдлыг онон тогтох аргыг прагматизм гэж үзсэн байна. Уильям Жеймс “радикал эмпиризмийн” үзэл баримтлал дэвшүүлсэн нь туршлага ба бодит чанарыг адилтгажээ. Тэрээр “Бодит байдал бол санамсаргүй үйл явцын холимог, ‘олон уургальч орчлон’ юм. түүний адил туршлага нь ухамсрын адил тэгш байдлын хувьд сэрэл, сэтгэлийн хөдөлгөөн, зүүд, харааны ба сонсголын хий үзэгдэл, шашны ба спирит сэтгэцийг багтаана. Ингэхлээр туршлагыг махизмын янзаар “саармаг” нэгэн мэт үзэж байна. Энэ нь танин мэдэгч субъектын ухамсрын байдал, мөн танин мэдэгдэгч объект юм” гэжээ. Өөрөөр хэлбэл, У.Жеймс “прагматизм бол зөвхөн арга” юм гэж үзсэн байна. Ж.Дьюи “Инструментализм бол шинжлэх ухааны универсаль арга. Аливаа болзошгүй нөхцөл байдалд асуудал шийдэх төдийгүй, хүмүүсийн бүх амьдралыг шинжлэх ухааны үндэстэй шийдэх арга мөн хэмээн үзжээ. Асуудалт нөхцөл байдлыг инструментализм хүнд тохиолддог объектив нөхцөлийн хувьд бус, харин объектив нөхцөл байдлаас үл хамаарах, хүний субъектив байдал, дотоод эргэлзээ гэж тайлбарладаг. Ойлголт, онол бол танин мэдэх үүрэг гүйцэтгэж буй оюуны хэрэгсэл биш, зөвхөн “асуудалт нөхцөл байдлаас” гарахад хэрэглэх багаж зэвсэг юм. Энэ утгаараа прагматик хандлага бол үзэл суртал биш бөгөөд практикт тулгуурласан арга хэрэгсэл юм.

Түлхүүр үг: Үзэл суртал, үнэт зүйлс, үзэл баримтлал, улс төрийн нам, нийгмийн давхраажилт, ардчилал, прагматик хандлага,

Товч хураангуй: Уг өгүүлэл улс төрийн үзэл суртлын үндэс, орчин үеийн улс төрийн намуудын үзэл баримтлал дахь прагматик хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзэн, шинжлэх ухааны товч тайлбар өгөхөд чиглэгдсэн.

ABSTRACT

The article is mentioned about non ideology of political parties in academic level. The origins of political parties are based on saving the idealism of social groups interest. Here is shortly mentioned about ideology and political party's activities. There is taken a note about differences of some modern ideological categories and their value. Although, ideological comments to define equal right is clearly shown in the social scale and group standards. This case has defined the base of idealism and materialism.

A modern ideological trend has developed with those 4 factors under belloyed. First: To take into consideration on average voter's desire. Second: process to take into consideration on typical value of democracy is taken as important by any political parties. Third: purpose to national renewal makes close to ideologies due to recognizing the factors of some political party's certain condition. Fourth: globalism, during the period of information era, political parties forced to abide united attitude for reason of accepting international legislation, right and rules, information wave and coordinating, local right to overcome and existing. Fifth: economical liberalization in worldwide, make a one's goal in the market competition, there is a part to saving the monopole status, another part coordinate to reach at their standard, a third part to find and set up their own attitude in world market. There is a requirement for ideology of any country's political parties concentrate in one certain direction.

Modern social different ideology has lost the importance. There is some reasons of influence are under belloyed: the process of nationalism and globalization requires political parties to work pragmatic. Although, political parties more considered about reflect on what average voters idea are. In those factors, the common purpose is to direct the state by political parties. This is a condition of having few certain symbol monopole parties in society.

НОМ ЗҮЙ

1. А.Гидденс. Социологи. УБ., 2006.
2. Ф.Фукуяама. Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн. УБ., Монсудар ХГ. 2006.
3. Ц.Ганболд, Ц.Батболд. Төрийн удирдлагын хөгжлийн түүхэн үе шатууд. /Төрийн захиргаа сэтгүүл/ 2010 № 01(11).
4. Ж.Штиглиц. Тогтвортой өсөлтөнд хүрэхийн тулд Зүүний үзлийг дага. Орч Д.Бадамдаш. <http://www.openforum.mn>
5. М.Дюверже. Политические партии. Пер Зимина Л.Й. 2000. <http://www.yandex.ru>
6. Ла Паломбара, Ж.Сартори. Политические партии. <http://www.sibupk.nsk.su>
7. Размышления о революции во Франции. London: Overseas Publications Interchange Ltd, 1992 (то же: М.: Рудомино, 1993)
8. Barth Hans. 1976. Truth and ideology. Los Angeles., UNIVERCITY OF CALIFORNIA PRESS
9. Kennedy Emmet. 1979. "Ideology" from Destutt De Tracy to Marx, Journal of the History of Ideas, Vol. 40, No. 3, www.jstor.org
10. Mannheim Karl. 1936. Ideology and Utopia. By Routledge. Transferred to digital printing 2003. <http://books.google.com/books?dq=Mannheim,+Karl>